



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 08

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.6, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннаймдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 33,979,175.78 (гучин гурван сая есөн зуун далан есөн мянга нэг зуун далан таван төгрөг далан найман мөнгө) төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй конторын барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үл хөдлөх хөрөнгө акталснаас гарсан материалыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах, худалдсанаас орсон орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 100 хувь төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн
дугаар тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын актлах барилгын мэдээлэл

Д/ Д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагд сан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Конторын барилга	1957	ш	1	33,979,175.78	33,979,175.78	-
	Нийт хөрөнгийн дүн				33,979,175.78 (гучин гурван сая есөн зуун далан есөн мянга нэг зуун далан таван төгрөг далан найман мөнгө) төгрөг	33,979,175.78 (гучин гурван сая есөн зуун далан есөн мянга нэг зуун далан таван төгрөг далан найман мөнгө) төгрөг	